



Хэвлэлийн мэдээ
2016 оны 3-р сарын 22

Холбогдох
+976 97109009

**Монгол дахь Америкийн Худалдааны Танхим
Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг
дахин нухацтай эргэж харахыг уриалав**

УЛААНБААТАР – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) нь Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхээс өмнө бизнесийн салбарынхан болон ажил олгогчдийн санал, хүсэлтийг тусгах боломжийг олгосон Монгол Улсын Хөдөлмөрийн Яаманд талархалаа илэрхийлж байна. АмЧам Монгол нь цаг үргэлж гишүүн компаниудынхаа ашиг сонирхолыг хамгаалж дэмжихийн төлөө ажилладаг ба ажилтан, ажил олгогч хоёрын эрх ашиг, сонирхлын харилцааг тэнцвэртэйгээр тусгаж чадсан боловсронгуй хөдөлмөрийн хуультай байх нь Монголд чөлөөт зах зээлийг улам хөгжүүлэх, Америкийн бизнес эрхлэгчдийг болон хөрөнгө оруулалтыг Монголд татахад ихээхэн чухал ач холбогдолтой байх болно гэж үзэж байна.

АмЧам Монгол нь Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өөрийн гишүүн байгууллагууд болон Монголын тэргүүлэх бизнесүүдийн төлөөллийн саналыг авч тусгах ажлыг манлайлан олон тооны хэлэлцүүлэг, шүүмжийн үр дүнд энэхүү хуулийн төсөлтэй холбоотой тодорхой саналуудыг нэгтгэж Хөдөлмөрийн Яаманд хүргүүлсэн болно.

АмЧам Монголын зүгээс Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, агуулга болон бүтцийг эргэн харж, нухацтай шинжилж дүгнэх зайлшгүй шаардлага байгааг онцолж байгаа ба одоогийн шинэчилсэн найруулга нь бусад хууль тогтоомж болон байгууллагын дотоод журмаар зохицуулж болох ба тэгэх шаардлагатай ажилтан, ажил олгогч хоёрын хооронд үүсэх олон харилцааг хуульчлахыг оролдсон байгаад анхаарлаа хандуулахыг уриалж байна.

Бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа цаашид тэлж өргөжүүлэх, шинээр эхэлж буй бизнес эрхлэгчид зах зээлд байр сууриа олоход ажилтан, ажил олгогч хоёрын харилцааг ийнхүү хатуу хуульчлах нь хамгийн ихээр сөрөг нөлөөг үзүүлэх билээ. Тиймээс АмЧам Монгол болон бусад бизнесийн холбоодоор дамжуулан Монголын бизнес эрхлэгчдийн саналыг анхааралтай хүлээн авч Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дахин нухацтайгаар эргэж харж бидний саналыг тусган авахыг Монгол улсын Хөдөлмөрийн Яаманд уриалж байна.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хооронд бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбарын статустай. Вашингтон ДиСид байрладаг Америкийн Худалдааны Танхим нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.